



### ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

JAICAF байгууллага нь 2015 оноос эхлэн Монгол улсад зөгийн аж ахуйг хөгжүүлэхэд чиглэсэн төсөл хэрэгжүүлж байна. (ЖАЙКА, Өвсний үндэс хөтөлбөр, техникийн хамтын ажиллагааны төсөл). 2018 оны 3-р сар хүртэл хэрэгжүүлсэн төслийн 1-р үе шатанд (Зөгийн аж ахуйг дэмжих замаар иргэдийн орлогыг нэмэгдүүлэх төсөл) Сэлэнгэ аймгийн зөгийн аж ахуй эрхлэгчдийг дэмжих чиглэлээр ажилласан буюу бүлд ногдох балны авцыг нэмэгдүүлэх, эмийн хэрэглээний менежментийг нэвтрүүлэх, зөгийчдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэж ажилласан. Үүний үр дүнд бүлд ногдох балны авц болон зөгий аж ахуйн орлого хоёр дахин нэмэгдэж, нийт балны талаас илүү нь эмийн хэрэглээний хяналт хийгдсэн үр дүнг үзүүлсэн. Мөн технологийн гарын авлага боловсруулсан нь бусад олон улсын байгууллага, төрийн бус байгууллагуудын сургалтанд ашиглагдаж байна.

**BeeDep-MONGOL 2 төсөл нь 2019 оны 3-р сараас эхлэн хоёр дахь шатны үйл ажиллагаагаа хэрэгжүүлж байна. Дархан-уул аймагт хэрэгжиж буй загвар үйл ажиллагааг үндэслэн ЗАА-н хөгжлийг дэмжих нэгдсэн гарын авлага бий болгохоор зорин ажиллаж байна.**

Шинэ Корона вирусийн халдварын улмаас 2020 оны 3-р сараас эхлэн алсын зайнаас ажиллах шаардлага тулгарсан бөгөөд бид дараах үйл ажиллагааг хэрэгжүүлэв.

- Төслийн зөвлөлдөх багийн анхдугаар хурал (2019 оны 5-р сар)
- Зөгийн улирал бүрийн маллагааны сургалт, дадлага (Дархан-уул, Хэнтий, Хөвсгөл, Дорнод аймгуудад)
- Цахимаар хийсэн цуврал сургалтууд (Төслийн фэйсбүүк хуудсанд байршуулав)
- Зөгийн балны чанарын болон маркетингийн менежмент
- Зөгийн маллагаа, бүтээгдэхүүний чанар болон ЗАА-н бизнес менежмент сэдэвт гарын авлага боловсруулав. (Урьдчилсан хэвлэл)
- Япон дахь сургалт (2019 оны 12-р сард. ЗАА-тай хатран ажиллаж буй байгууллагуудын 6 мэргэжилтэн)

Цаашид цахим сургалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах ба COVID-19 –ийн нөхцөл байдлаас шалтгаалах боловч орон нутаг дахь сургалт, дадлагыг хийхээр төлөвлөж байна.

### Зөвлөлдөх багийн 2 дугаар хуралдаан боллоо.

2021 оны 1-р сарын 18 –ны өдөр тус төслийн зөвлөлдөх багийн 2 дугаар хурлыг онлайнаар зохион байгуулав.

Зөвлөлдөх багийн бүрэлдэхүүнд хамтран хэрэгжүүлэгч ХХААХҮЯ болон холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд багтдаг.

Энэ удаагийн хурлаар төслөөс 2020 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг хэлэлцэв. Мөн цаашид хийх ажлын төлөвлөгөө, төслийн ернхий загвар (PDM)-ийн зарим хэсэгт өөрчлөлт хийх тухай хэлэлцэв.




### ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА ①



#### Төслийн менежер АКИЁО НИШИЯМА

Зөгийчид болон малын эмч нар хамтран зөгийн бүлд анхаарал тавьж байгаа нь сайшаалтай эхлэл юм. Монголын байгалийн цэцэгсийг олон болгож буй бяцхан зөгийг анзаахагүй байхын аргагүй билээ.



#### ЗАА-н технологийн мэргэжилтэн

#### ХИДЭХИРО ХОШИБА

Монгол болон Япон орны хувьд цаг уур, балт ургамлын төрөл зэрэг ялгаатай зүйлүүд байгаа боловч зөгий маллах технологийн үндэс нь ижил юм. Иймээс миний зүгээс зөгий маллах үндсэн аргыг зааж сургадаг. Үүнд үндэслэн Монголын зөгийн аж ахуйн технологийг хөгжүүлээсэй гэж хүсэж байна.

Төслийн Facebook :

[www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin\\_todo\\_tour](https://www.facebook.com/BeeDep-MONGOL-2-107843977265085/?modal=admin_todo_tour)

**Онлайн семинарыг хүргэж байна !**

